

Худгийн ажлын техникийн тодорхойлолт

- Байгаль орчны яамны усны мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх
 - Заалт: цооног өрөмдөх, сэргээн засварлах, тоноглох, усны барилга байгууламж барих
- Цэвдэгтэй бүс нутагт өрөмдлөг, хайгуул судалгааны ажил хийж байсан ажлын туршлагатай байх.
- Өрөмдлөгийн ажил эхлэхээс өмнө тухайн цэгт усны, цэвдгийн нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийх тул өөрийн хайгуул судалгааны багаж, тоног төхөөрөмжтэй байх, түүний танилцуулгыг хавсралт болгох.
- Цооног өрөмдөж, худаг гаргах байршил нь цэвдэгтэй байж болох бүс нутагт хамаарах тул дараа гарах эрсдэлийг тооцож тухайн чиглэлээр Монгол улсад хууль ёсны үйл ажиллагаа явуулдаг албан байгууллагатай хамтарч ажиллах гэрээтэй байх, Гэрээний хуулбар хувийг хавсралт болгох.
- Цэвдэгтэй бүс нутагт худаг гаргах түүнийг хөлдөөхгүй ашиглах арга, аргачлалын тухай мэргэжлийн хүний тайлбар ирүүлэх.
- Цэвдэгтэй бүс нутагт худаг гаргах түүнийг хөлдөөхгүй тоног төхөөрөмж суурилуулах, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг бүрэн хангах, шаардлагатай тохиолдолд зориулалтын байшин бариж хамгаалах, зааварчилгаагаар хангах.
- 2018, 2019 онуудад хийгдсэн ажлын акт, ашиглагч байгууллагын тодорхойлолт заавал хавсралт болгох. Тус тодорхойлолтод: хийгдсэн ажлын үр дүн, түүний одоогийн нөхцөл байдал ямар байгаа эсэх тодорхой бичсэн байна. Энэ нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
- Цэвдэг судлалын мэргэжлийн үүн дотроо мэргэшсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага эсвэл ТББ-тай хамтарч ажиллах гэрээ байгуулсан байх.

Боловсруулсан: ЗДТГ-ын Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн зөвлөх ажилтан

Гарын үсэг.....*Т. Дашцэрмаа*..... Т. Дашцэрмаа